



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 05 өдөр

Дугаар А/427

Улаанбаатар хот

Химийн хордлогыг тандах, бүртгэх,
мэдээлэх журмыг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг, Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2.3 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Химийн хордлогыг тандах, бүртгэх, мэдээлэх журам"-ыг нэгдүгээр, "Химийн хордлогын тандах, бүртгэх, мэдээлэх үе шат"-ыг хоёрдугаар, "Химийн хордлогын тохиолдолд суурилсан тандалтыг бүртгэх, мэдээлэх маяг"-ыг гуравдугаар, "Химийн хордлогыг тандах тархвар судалгааны хуудас"-ыг дөрөвдүгээр, "Химийн хордлогын дэгдэлт-үйл явдалд суурилсан тандалтын мэдээг бүртгэх хуудас"-ыг тавдугаар, "Химийн бодисын ангилал, хордлогот өвчний үед илрэх эмнэл зүйн шинж тэмдгийн лавлагаа"-г зургаадугаар, "Химийн хордлогот өвчний олон улсын ангиллын лавлагаа"-г долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Химийн хордлогыг тандах, бүртгэх, мэдээлэх журмын хэрэгжилтийг ханган, салбар хоорондын уялдааг зохицуулж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар болон бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд)-т даалгасугай.
4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 467 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



141224838

12

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
12 дугаар сарын 05 ны өдрийн 12 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

ХИМИЙН ХОРДЛОГЫГ ТАНДАХ, БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Химийн хордлогын тохиолдол, дэгдэлт-үйл явдлыг тандах, бүртгэх, мэдээлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, тархвар судлалын оношийг баталгаажуулах, хордлогын эх үүсвэр, шалтгаан, хамрах хүрээ, тархалтын түвшинг тогтоох, эргэн мэдээлэх, хариу арга хэмжээ авах харилцааг энэ журмаар зохицуулна.

2. Химийн хордлогын тохиолдол, дэгдэлт-үйл явдал нь техник, мэргэжлийн чадавх, дотоод нөөцөөс давсан, их хэмжээний хохирол учруулахаар бол Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу хариу арга хэмжээ авах бөгөөд уг харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

3. Химийн хордлогыг тандах, бүртгэх, мэдээлэх, урьдчилан сэргийлэхэд аймаг, нийслэл, сум, дүүрэг, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбогдох бүх шатны эрүүл мэндийн байгууллага болон Цэргийн төв эмнэлгийн Хордлогын яаралтай тусламжийн төв дэмжлэг үзүүлж ажиллана.

4. Химийн хордлогын тандалт нь шалтгаан тодорхойгүй, цаашид тархах, хүрээлэн буй орчин бохирдох, хүний эрүүл мэнд, амь нас эрсдэхээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

5. Химийн хордлогыг тандах, мэдээлэх үйл ажиллагаанд хордлогын талаарх яаралтай болон тогтмол мэдээг хүлээн авах, бүртгэх, эрсдэлийн үнэлгээ хийх, тархвар судлалын оношийг баталгаажуулах, хордлогын эх үүсвэр, шалтгаан, хамрах хүрээ, тархалтын түвшинг тогтоох, эргэн мэдээлэх болон бусад хариу арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагаа хамаарна.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. "химийн бодис" гэж химийн тогтмол найрлагатай, өөрийн тодорхой шинж чанарыг агуулсан материйн хэлбэрийг;

2.1.2. "химийн хордлого" гэж химийн бодисын нөлөөгөөр хүний бие махбод, эрхтэн, тогтолцооны бүтэц, үйл ажиллагаанд эмгэг үүсэхийг;

2.1.3. "химийн аюултай бодис" гэж тэсрэмтгий, шатамхай, цочромтгой, исэлдүүлэгч болон идэмхий шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг;

2.1.4. "химийн хортой бодис" гэж хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор, аюул учруулах шинж чанартай химийн бодисыг;

2.1.5. "цочмог хордлого" гэж химийн бодис, түүний үйлчлэлийн нөлөөгөөр хүний бие махбод, бодисын солилцоонд өөрчлөлт орох, эд эрхтэн богино хугацаанд өртөж, амь насанд аюул учрах, үхэлд хүргэх байдлаар илрэх хурц эмгэгийг;

2.1.6. "архаг хордлого" гэж химийн бодисын үйлчлэлийн нөлөөгөөр хүний бие махбод удаан хугацаанд хордож, өвчин эмгэг үүсэхийг;

2.1.7. "химийн хордлогын голомт" гэж химийн хортой, аюултай бодисын бохирдолд өртсөн газар, талбай, нутаг дэвсгэрийг;

2.1.8. "дэгдэлт" гэж ижил төрлийн эмнэл зүйн шинж тэмдэг илэрсэн хоёр ба

түүнээс дээш химийн хордлогын голомтыг;

2.1.9. "тохиолдолд суурилсан тандалт" гэж химийн хордлогын улмаас үүссэн өвчний хам шинж, сэжигтэй, өвөрмөц тохиолдлыг тогтсон хугацаанд мэдээлэх, хариу арга хэмжээ авах, эргэн мэдээлэх үйл ажиллагааг;

2.1.10. "дэгдэлт-үйл явдалд суурилсан тандалт" гэж эрүүл мэндэд ноцтой нөлөөлж болзошгүй өвчний шинж тэмдэг, тэдгээрийг үүсгэх хүчин зүйлсийн талаарх мэдээллийг цуглуулж, нягтлан баталгаажуулах, хариу арга хэмжээ авах, эргэн мэдээлэх үйл ажиллагааг;

2.1.11. "сэжигтэй тохиолдол" гэж өвчний нууц үеийн дотор тухайн өвчинд өртсөн, өвчин үүсгэгч хүчин зүйл (химийн бодис) өвчтөнөөс авсан шинжлэгдэхүүн болон эрүүл зүйн шинжилгээний сорьцод хийсэн лабораторийн шинжилгээгээр батлагдаагүй, эсвэл шинжилгээ хийгдээгүй боловч эмнэл зүйн өвөрмөц шинж тэмдэг илэрсэн тохиолдлыг;

2.1.12. "магадлалтай тохиолдол" гэж өвчний нууц үеийн дотор тухайн өвчин үүсгэх хүчин зүйлс (хор болон бусад)-д өртсөн, эрүүл зүйн лабораторийн шинжилгээгээр батлагдсан боловч өвчтөнөөс авсан шинжлэгдэхүүнд өвчин үүсгэх тодорхой хүчин зүйл илрээгүй буюу өвчин бүрэн батлагдаагүй, эсвэл шинжилгээ хийгдээгүй боловч эмнэл зүйн өвөрмөц шинж тэмдэг илэрсэн, сэжигтэй тохиолдлыг;

2.1.13. "батлагдсан тохиолдол" гэж нууц үед тухайн үүсгэгчид өртсөн, лабораторийн шинжилгээний дүн эерэг (хор болон бусад шалтгааны хүчин зүйл илэрсэн эсвэл ийлдэс судлалын сорил эерэг гарсан), эмнэл зүйн өвөрмөц шинж тэмдэг илэрсэн хүнийг;

2.1.14. "нууц үе" гэж химийн хордлогод өртсөнөөс хойш анхны шинж тэмдэг илрэх хүртэлх хугацааг;

2.1.15. "эрсдэлийн үнэлгээ" гэж аюулыг тодорхойлж, аюулд өртөх магадлалыг тооцон, өртсөн тохиолдолд гарч болох үр дагаврыг чанарын болон тоон аргаар үнэлэх аргачлалыг;

Гурав. Химийн хордлогыг тандах, бүртгэх, мэдээлэх үйл ажиллагаа

3.1. Энэ журмыг хэрэгжүүлэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, шийдвэр гаргагч нарыг нотолгоонд суурилсан мэдээллээр хангах, төлөвлөх, эмнэлгийн мэргэжилтнийг сургах, зөвлөмжөөр хангах ажлыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (цаашид "НЭМҮТ" гэх)-ийн хор судлал, шуурхай удирдлагын нэгж хариуцан гүйцэтгэнэ. Химийн хордлогын тандалтыг тохиолдолд суурилсан болон дэгдэлт-үйл явдалд суурилсан аргачлалаар зохион байгуулна.

3.2. Химийн хордлогын тандалтын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын тархвар судлаач эсвэл биостатистикч эмч хариуцаж, тухайн орон нутгийн онцгой байдал, байгаль орчны хяналт, мал эмнэлгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллана.

3.3. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн "H-info" болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын "E-health" программд НЭМҮТ-д нэвтрэх, өгөгдөл дамжуулах эрхийн зөвшөөрлийг олгох, холбогдсон өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд химийн бодисын хордлогын батлагдсан тохиолдлыг өдөр тутам бүртгэж, цахим мэдээллийн сан үүсгэнэ.

3.4. Батлан хамгаалах яамны харьяа Цэргийн төв эмнэлэг нь яаралтай тусламж үзүүлэх хуудсаар бүртгэж, сар бүр нэгтгэсэн тайланг НЭМҮТ-ийн хор судлал, шуурхай удирдлагын нэгжид ncph.info@gmail.com цахим хаягаар дараа сарын 05-ны дотор хүргүүлнэ.

3.5. "H-info" болон "E-health" программд холбогдоогүй бусад эрүүл мэндийн байгууллагууд химийн бодисын хордлогын тохиолдолд суурилсан тандалтыг батлагдсан маягтын дагуу бүртгэж, мэдээллийн сан үүсгэнэ. Тайланг цахим болон цаасан хэлбэрээр заасан хугацаанд Эрүүл мэндийн хөгжлийн төв болон НЭМҮТ-ийн хор судлал, шуурхай удирдлагын нэгжид тогтмол хүргүүлнэ.

3.6. НЭМҮТ-ийн хор судлал, шуурхай удирдлагын нэгж нь Эрүүл мэндийн хөгжлийн төвийн "H-info" программ болон бусад хэлбэрээр ирүүлсэн тайланг тандалтын тусгай программд хөрвүүлэн боловсруулж, дүн шинжилгээ хийн, цахим мэдээллийн санд нэгтгэнэ.

3.7. Тандалтын мэдээг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, шалтгаан, хамаарлыг тогтоохдоо Үндэсний статистикийн хорооноос гаргасан хүн ам зүйн үзүүлэлт, статистик мэдээг ашиглана.

3.8. Химийн хордлогод хамаарах үйлдвэрлэлийн хурц хордлогыг Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн дагуу бүртгэж мэдээлнэ.

3.9. Химийн хордлогод хамаарах хүнсний химийн хордлогыг Хоол хүнсээр дамжих өвчнийг тандах, хянах журамд заасны дагуу бүртгэж мэдээлнэ.

Дөрөв. Тохиолдолд суурилсан тандалт

4.1. Химийн хордлогын тохиолдолд суурилсан тандалтын үйл ажиллагаанд Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Статистикийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалаар баталсан Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журмыг баримтална.

4.2. Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагууд өдөр тутмын амбулаторийн үзлэг болон хэвтэн эмчлүүлэгчдийн үзлэгээр химийн бодисын хордлогын тохиолдолд суурилсан тандалт хийнэ. Химийн бодисын хордлогын батлагдсан тохиолдол бүрийг өвчний олон улсын 10 дугаар ангиллын дагуу кодлон АМ1А,Б маягтаар бүртгэн, "H-info" программын мэдээллийн санд нэгтгэнэ.

4.3. Үндсэн онош буюу үндсэн өвчний код нь тухайн өвчний мөн чанарыг харуулах ба энэ нь өвчний олон улсын ангиллын XIX бүлгийн код байна.

4.4. Химийн хордлогын сэжигтэй болон магадлалтай тохиолдолд өвчтөн, хавьтагчдаас авсан шинжлэгдэхүүнийг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн нарийн мэргэжлийн болон клиникийн эмнэлэг, хувийн эмнэлгийн магадлан итгэмжлэгдсэн лаборатори, шаардлагатай тохиолдолд хувийн хэвшлийн итгэмжлэгдсэн лаборатори болон НЭМҮТ-ийн лавлагаа лабораторид өгч шинжлүүлэн, онош баталгаажсан тохиолдолд мэдээллийн санд бүртгэж, мэдээлнэ.

4.5. Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн, биостатистикч эмч нар химийн бодисын хордлогын тохиолдолд суурилсан тандалтын цахим мэдээллийн сангаас сарын тайланг дараа сарын 10-ны дотор, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор, жилийн тайланг тухайн оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгон дараа жилийн 01 дүгээр сарын 10-ны дотор нэгтгэн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

4.6. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь эрүүл мэндийн байгууллагуудын тайланг батлагдсан маягтын дагуу нэгтгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвд цахим болон цаасан хэлбэрээр баталгаажуулан хүргүүлнэ.

4.7. НЭМҮТ-ийн хор судлал, шуурхай удирдлагын нэгж нь химийн бодисын хордлогын сар, улирал, жилийн тайлан мэдээг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн "H-info" программаас хөрвүүлэн авч, нэгдсэн цахим мэдээллийн сан үүсгэнэ.

4.8. НЭМҮТ-ийн хор судлал, шуурхай удирдлагын нэгж нь цахим мэдээллийн сангийн нэгтгэлийг Эрүүл мэндийн яаманд сар бүрийн 15-ны дотор, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн тайланг дараа жилийн 01 дүгээр сарын 20-ны дотор тус тус тайлагнаж, холбогдох байгууллагыг мэдээллээр ханган, хариу арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагааг хариуцна.

4.9. Химийн бодисын нөлөөгөөр нийгмийн эрүүл мэндэд ноцтой эрсдэл үүссэн болон Засгийн газрын тогтоол, яам, агентлагийн тушаал, шийдвэрээр химийн бодисын хордлогын мэдээг хугацаа харгалзахгүй гаргуулан авч болно.

Тав. Дэгдэлт-үйл явдалд суурилсан тандалт

5.1. Химийн хордлогын дэгдэлт-үйл явдалд суурилсан тандалтыг Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Гамшгийн тухай хууль, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалыг баримтлан зохион байгуулна.


5.2. НЭМҮТ-ийн хор судлал, шуурхай удирдлагын нэгж нь химийн хордлогын дэгдэлт-үйл явдалд суурилсан тандалтын мэдээг батлагдсан маягтын дагуу хүлээн авч, мэдээллийн сан үүсгэнэ.

5.3. Химийн хордлогын дэгдэлт болон үйл явдалд суурилсан тандалтын мэдээг анх оношилсон эрүүл мэндийн байгууллагын ажилтан батлагдсан маягтын дагуу бүртгэж, 2 цагийн дотор аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын Онцгой байдлын хэлтэс, химийн бодисын аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, НЭМҮТ-ийн хор судлал, шуурхай удирдлагын нэгж (ncph.info@gmail.com) цахим хаягаар шуурхай мэдээлнэ.

5.4. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар холбогдох бусад байгууллагатай хамтран хордлогын голомтот бүсэд тархвар судлалын тандалт судалгаа, хяналтыг зохион байгуулж, эрүүл зүйн ба эмнэл зүйн хамтарсан урьдчилсан дүгнэлтийг Эрүүл мэндийн яаманд 6 цагийн дотор мэдээлнэ.

5.5. Дэгдэлт-үйл явдал гэж үзсэн даруйд химийн хордлогын дэгдэлт-үйл явдалд суурилсан тандалтын эрсдэлийн үнэлгээг Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын дагуу Онцгой байдлын ерөнхий газар болон НЭМҮТ-ийн хор судлал, шуурхай удирдлагын нэгж холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран гүйцэтгэж, эрсдэлийн үнэлгээнээс хамаарч хариу арга хэмжээг шуурхай төлөвлөн ажиллана.

Хоёр. Дэгдэлт-Үйл явдалд суурилсан тандалт



12 дугаар сарын 05-ны өдрийн 122 дугаар
тушаалын 3 дугаар хавсралт

**ХИМИЙН ХОРДЛОГЫН ТОХИОЛДОЛД СУУРИЛСАН
ТАНДАЛТЫГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ МАЯГТ**

№	Мэдээлэл	Тайлбар
1.	Хордлогын тохиолдлын огноо	
2.	Хордлого анх илэрсэн газрын хаяг, байршил	
3.	Өртсөн хүний овог нэр	
4.	Өртсөн хүний нас, хүйс	
5.	Өртсөн хүний регистрийн дугаар	
6.	Хордлогын шалтгаан	
7.	Онош	
8.	Оношийг лабораториор баталгаажуулсан эсэх	
9.	Өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлсэн эсэх	
10.	Өвчтөний тавилан	
11.	Мэдээлсэн хүний овог, нэр	
12.	Мэдээлсэн хүний албан тушаал, ажлын газрын хаяг	
13.	Мэдээлсэн хүний холбоо барих дугаар	

ХИМИЙН ХОРДЛОГЫГ НЭГТГЭН МЭДЭЭЛЭХ МАЯГТ

№	Нийслэл/Аймаг/ Дүүрэг/Эмнэлгийн нэр	Илэрсэн хордлогын тохиолдлын тоо	Хордлогын шалтгаан	Хордлогын улмаас нас барсан хүний тоо	Тайлбар

Мэдээлсэн хүний овог, нэр:

Албан тушаал, ажлын газрын хаяг

Холбоо барих утасны дугаар:

12

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
 12 дугаар сарын 25-ны өдрийн 1422 дугаар
 тушаалын 4 дүгээр хавсралт

ХИМИЙН ХОРДЛОГЫГ ТАНДАХ ТАРХВАР СУДАЛГААНЫ ХУУДАС

Өвчтөнд илэрч буй эмнэл зүйн шинж тэмдэг:	
Эмнэлгийн нэр:	Огноо:
Үзлэг хийсэн эмчийн нэр:	Цаг:
Өвчтөний овог:	Өвчтөний нэр:
Хүйс: эрэгтэй эмэгтэй Нас:..... Ам бүл:.....	Регистрийн дугаар:
Гэрийн хаяг:	
Оршин суугаа улс:	Иргэншил:
Оршин суугаа хот:	Утасны дугаар:
Цахим шуудангийн хаяг:	ЭМД-ын дугаар:
Өвчтөн химийн бодист өртсөн үү?	Тийм Үгүй Эргэлзээтэй
Хэрэв тийм бол өртсөн огноо:	
Хаана, хэрхэн өртсөн тухай мэдээлэл:	
Хордсон дарууд арга хэмжээ авсан эсэх:	Тийм Үгүй
Өвчтөнд хордлогын ямар нэгэн шинж тэмдэг илэрсэн:	Тийм Үгүй
Хэрэв тийм бол ямар шинж тэмдэг илэрсэн талаар:	
Хордлогын шинж тэмдэг анх илэрсэн огноо:	
Химийн бодисын нэр, шинж байдал:	
Химийн бодисын физик төлөв:	Хатуу Шингэн Уур/хий Мэдэхгүй
Өртсөн зам:	Амьсгалаар Амаар Арьсаар Мэдэхгүй
Өвчтөний ухаан санааны байдал:	Асуултад хариулах чадвартай Ухаан саруул Өвдөлтийг мэдэрнэ Ухаангүй
Лабораторийн шинжилгээ хийсэн эсэх:	Тийм Үгүй
Өвчний шалтгаан үүсгэгч:	
Химийн хордлогын хам шинж, тохиолдлын тодорхойлолт:	Батлагдсан Сэжигтэй Магадлалтай

Эцсийн онош:

.....

Лабораториор Эмнэл зүйгээр Тархвар судлалаар

Дүгнэлт гаргасан: Тархвар судлагч эмч:

Амбулатори/Стационарын эмч:

--- ооо ---



**ХИМИЙН ХОРДЛОГЫН ДЭГДЭЛТ-ҮЙЛ ЯВДАЛД СУУРИЛСАН ТАНДАЛТЫН
 МЭДЭЭГ БҮРТГЭХ ХУУДАС**

1.	Үйл явдлын төрөл:	Хүний халдварт өвчин Мал, амьтны халдварт өвчин, гэнэтийн хорогдол Зоонозын шалтгаант халдварт өвчин Химийн осол, хордлого Хоолны хордлого, хордлогот халдвар Байгалийн гамшиг Химийн бодисын алдагдал Цацрагийн хордлого Шалтгаан нь тодорхойгүй өвчлөл, нас баралт Террорист халдлага Олны хамарсан эмх замбараагүй байдал, осол гэмтэл Орчны бохирдол Бусад (бичих)
2.	Үйл явдал мэдээлэгдсэн огноо:	Он _____ сар _____ өдөр _____ цаг _____ мин _____
3.	Эх сурвалж:	Байгууллага Иргэн Интернэт мэдээлэл Телевиз Радио Сонин хэвлэл Эмч, мэргэжилтэн Лаборатори Бусад
4.	Үйл явдлыг мэдээлсэн:	Байгууллага, мэргэжилтний нэр, утас:
5.	Үйл явдал хаана болсон:	Google map:
6.	Үйл явдал эхэлсэн огноо:	Он _____ сар _____ өдөр _____ цаг _____ мин _____
7.	Өртсөн: Хүний тоо Малын тоо Амьтны тоо..... Орчин (газар нутаг) Талбайн хэмжээ Объект.....	
8.	Нас барсан: Хүний тоо Малын тоо	

	Амьтны тоо..... Эвдэрсэн сүйрсэн: Объектын тоо.....	
9.	Лабораторийн шинжилгээнд дээж/сорьц авсан эсэх:	Тийм Үгүй
10.	Дээж/сорьцын төрөл:	
11.	Лабораторийн шинжилгээний дүн:	
12.	Нэмэлт мэдээлэл:	
13.	Мэдээлсэн:	Байгууллага:..... Албан тушаал:..... Нэр:..... Гарын үсэг:.....

--- оОо ---

ХИМИЙН БОДИСЫН АНГИЛАЛ, ХОРДЛОГОТ ӨВЧНИЙ ҮЕД ИЛРЭХ ЭМНЭЛ ЗҮЙН ШИНЖ ТЭМДГИЙН ЛАВЛАГАА

Нэг. Химийн бодисын эмнэл зүйн практикт түгээмэл ашиглах ангилал

№	Химийн бодисын ангилал	Тайлбар
1.	Үйлдвэрлэлийн химийн бодис	<ul style="list-style-type: none">- Органик уусгагч (дихлорэтан)- Шатахуун- Метан- Пропан- Бутан- Будагч (аналин)- Ферон- Спирт (метил, этил) гэх мэт
2.	Химийн хор	<ul style="list-style-type: none">- Хлорорганик пестицид (гексахлоран, полихлорфенамен)- Фосфорорганик инсектицид (карбофос, хлорфос, фосфамид, трихлорметафос-3, метилмеркаптофос)- Органик мөнгөн усны бэлдмэл (граназон),- Карбамины хүчлийн бүтээгдэхүүн (севин)- Байлдааны хорууд (зарин, иприт, фосген) гэх мэт
3.	Эмийн бодис	<ul style="list-style-type: none">- Нойрсуулагч- Тайвшруулагч- Зүрх судасны- Наркотик- Антибиотик- Био бэлдмэлүүд гэх мэт
4.	Ахуйн химийн бодис	<ul style="list-style-type: none">- Хүнсний нэмэлтүүд- Угаалга цэвэрлэгээний бодис- Гоо сайхны бүтээгдэхүүн гэх мэт
5.	Амьтны ургамлын хоронд	<ul style="list-style-type: none">- Мөөг- Ургамал- Могой- Зөгий- Ямаан ууц гэх мэт

Хоёр. Хортой бодисын хүний эрүүл мэндэд нөлөөлөх хоруу чанарын ангилал

№	Хортой бодисын төрөл	Нэгдлүүд
1.	Мэдрэл саажуулах хор /бүтэлт, таталт, саажилт/	Фосфорорганик бодис/ хлортфос, карбофос, никотин, анабазин, байлдааны хоронд, зарин/

2.	Арьс салстаар шимэгддэг хор /хэсэг газрын ба ерөнхий/	Дихлоэтан, гексахлоран, байлдааны хоронд / иприт, люизит/ цууны хүчил, хүнцэл, мөнгөн ус
3.	Ерөнхий үйлчилгээтэй хор /хүчилтөрөгчийн дутагдал, тахины хаван, шок, саажилт/	Нүүрстөрөгчийн дутуу исэл, этилийн спирт, байлдааны хоронд / синилийн хүчил буюу цианы хүчил, хлорциан/
4.	Амьсгал боогдуулагч хор (уушгины хаван)	Хлор, хлорликрин
5.	Нулимс асгаруулагч, цочроогч хор	Азотын дутуу исэл /фосген, дифосген/ см-ээс адамсит/ хүчил, шүлтийн уур
6.	Сэтгэл мэдрэлийн хор	Наркотик, атротик, байлдааны хоронд /ISD-лезиргины хүчлийн нэгдлүүд
7.	Хорт альбумин хор	Рицин, абрин

Гурав. Зарим химийн бодисын хордлогын үед илрэх эмнэл зүйн шинж тэмдэг

№	Хордлогын төрөл	Үүсгэгч, гол төлөөлөгч	Илрэх шинж тэмдэг
1.	Ерөнхий үйлчилгээтэй хордуулах бодисын хордлого	<ul style="list-style-type: none"> - Устөрөгчийн цианид буюу синилийн хүчил (Hydrogen cyanide, HCN) - Цианийн хлорид (Cyanogen chloride, CNCl) зэрэг циант нэгдлүүд - Нүүрстөрөгчийн дутуу исэл (Carbon monoxide, CO) 	<p>Хөнгөн зэргийн өртөлт: (Цусан дахь цианидын түвшин 2 мг/л-ээс доош)</p> <ul style="list-style-type: none"> - Толгой эргэж, өвдөлт өгнө - Бөөлжис хүрнэ - Амьсгаадаж цээж бачуурна - Айдас, түгшүүрт автана - Аманд металын амт амтагдана - Нүдний гэмтэл - Арьс цочрох <p>Дунд зэргийн өртөлт: (Цусан дахь цианидын түвшин 2-3 мг/л)</p> <ul style="list-style-type: none"> - Толгой эргэж, өвдөлт өгнө - Бөөлжис хүрнэ, бөөлжинө - Өртөлтөнд орсон хүн айдас сандралд орсон байна - Өртөлтөнд орсон хүний ухаан санаа самуурна - Амьсгаадна, цээж бачуурна - Таталт өгч, өртөлт удаан хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд комд орно <p>Хүнд зэргийн өртөлт: (Цусан дахь цианидын түвшин 3-4 мг/л)</p> <ul style="list-style-type: none"> - Ихэвчлэн амьсгал түргэн хугацаанд гүнзгийрч, аяндаа амьсгал тасалдаж эхлэнэ - 20-30 секундын дараа таталт үүснэ - Уналт, ком үүсэж, амьсгал зогсож, хэдэн минутын дотор хүүхэн хараа өргөснө

			<ul style="list-style-type: none"> - Хэвийн бус хөхрөлт үүсэж, заримдааарьс улаан ягаан өнгөтэй болно - Үхэлд хүргэнэ <p>Хожуу илрэх шинж:</p> <ul style="list-style-type: none"> - Самуурах - Сэтгэн бодох чадвар буурах - Дайвах - Паркинсоны өвчний шинж илрэх - Дүлийрэх - Ослын дараах хямралын шинж ажиглагдах
2.	Мэдрэлд нөлөөлөх фосфорорганик бодисуудын хордлого	<ul style="list-style-type: none"> - Зарин (sarin) - Зоман (soman) - Табун (tabun) - VX хий (C.A.S:5078269-9) - Мэрэгч - Шавж устгагч ахуйн ба үйлдвэрийн хорт бодис 	<p>Хөнгөн зэргийн өртөлт:</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэн хараа бага зэрэг нарийсна - Нүд өвдөж, хараа бүдгэрнэ - Нулимс, нус гоожно - Шүлс ихээр ялгарна - Нүд гөлийнө - Толгой өвдөж, бөөлжис цутгана - Хөнгөн зэргийн булчингийн сулрал илэрнэ - Хэсэг газрын булчингийн чичиргээ үүснэ - Хөнгөн зэргийн сандрал илэрнэ <p>Дунд зэргийн өртөлт:</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэн хараа нарийсаж, эвэрлэг бүрхэвч улайна - Толгой эргэж, зүг чиг алдана - Ханиалгах, амьсгаадах, найтаах шинжүүд илэрнэ - Шүлс гоожих, цэр ихээр гарах, гуурсан хоолойн шүүрэл ихсэх, гуурсан хоолойн агшилт илрэх - Амьсгалахад хүндрэлтэй болно - Булчин чичирнэ - Булчин суларч, ядарч, сульдана - Бөөлжих, суулгах, шээс ихээр ялгарах шинжүүд илэрнэ <p>Хүнд зэргийн өртөлт:</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэн хараа цэг хэмжээтэй болж нарийсна - Ухаан санаа самуурч, сандран - Татна - Шүүрлийн хэмжээ нэмэгдэнэ - Зүрхний хэм алдагдана - Ухаан алдана - Амьсгал зогсоно - Үхнэ <p>Хожуу илрэх шинж:</p>

			<ul style="list-style-type: none"> - 1-4 хоногийн дараа тархины цахилгаан бичлэгт өөрчлөлт илрэх - Төвлөрөх чадвар болон ой санамж муудах - Гэмтлийн дараах хямралын шинж илрэх - Амьсгалын цочмог дутагдал - Саажилт
3.	Сэтгэц, мэдрэлд нөлөөтэй буюу психотомиметик үйлчлэлтэй бодисуудын хордлого	<ul style="list-style-type: none"> - Лизергины хүчил агуулсан нэгдлүүд (LSD) - Псилоцибин (psilocybin) - Гармин (garmine) - Буфотенин (bufotenine) - Мескалин (mescaline) - Диметилтриптамин (dimethyltryptamine) зэрэг ургамлын гаралтай психотомиметикүүд - Бензилийн хүчлийн уламжлалууд (benzoic acid derivatives) - BZ хий - Дитран - N-метил-3-пиперидилбензилат - N-этил-3-пиперидилбензилат зэрэг нийлэг психотомиметикүүд 	<p>Лизергины хүчил агуулсан нэгдлүүдийн хордлогын шинжүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Хордолтоос 20-30 минутын дараа хордлогын шинж тэмдэг эхэлж, 1-2 цагийн дараа оргил үедээ хүрч 6-8 цаг үргэлжилнэ - Сэтгэхүйн хүлээн авах чадвар, вегатив ба эрхтэн тогтолцооны хямралтай хамт илэрнэ - Бие сулрах, ядрах, даарах, толгой эргэх, өвдөх, тайван бус болох - Хүүхэн хараа өргөсөх - Орчны юмсын хэлбэр өөрчлөгдөх - Цаг ба орчны баримжаа алдагдаж, өөрийгөө танихаа болино - Сонсголын болон нүдний харааны хий үзэгдэл үүснэ - Айдас үүсэж, өөрийн үйлдлийн бурууг мэдэрч, тусламж хүсэх боловч зөв шийдвэр гаргаж чадахгүй, нэрээ нэрлэж чадахгүй болно - Чих шуугих, толгой дүүрэх, нүд улайх, хүүхэн хараа өргөсөх шинж илэрнэ - Биеийн халуун нэмэгдэх, амьсгал гүнзгийрч удаашрах, хөдөлгөөний хямрал, гуйвах, булчин таталдах шинж илэрнэ - Хөдөлгөөний эвсэл алдагдах, таталт саажилт илэрнэ <p>BZ бүлгийн бодисуудын хордлогын шинж:</p> <ul style="list-style-type: none"> - Атропин тест хордлогыг үүсгэх онцлогтой - Хүүхэн хараа өргөсөх, ойрын хараа муудах, ам татах, арьс улайх, толгой эргэх - Төв мэдрэлийн тогтолцооны саажилтаас болж, нас барах эрсдэлтэй

4.	<p>Арьсаар дамжих, цэврүү үүсгэгч үйлчилгээтэй химийн бодисуудын хордлого</p>	<p>-Иприт (Solfuro di 2,2'-diclorodietile) буюу гичийн хий /mustard/,</p> <p>-Люизин (lewisite, 2-chloroethenylarsonous dichloride)</p>	<p>Иприт ба гичийн хийн хордлогыг оношлох:</p> <p>Цочмог нөлөөллийн үед Нүд: Хөнгөн зэргийн үед:</p> <ul style="list-style-type: none"> - Нууц үе 4-12 цаг байна. - Нулимс гоожин - Нүд нуухтана, улайж, өвдөнө. - Нүд орчмоор хөнгөн зэрэг хавагнана. - 1-2 долоо хоногийн дараа эдгэрнэ. <p>Дундаас хүнд зэргийн үед:</p> <ul style="list-style-type: none"> - Нууц үе 1-3 цаг - Зовхины булчин агших, зовхи буулгахад зовуурилна. - Ихэвчлэн түр зуур хараа алдана. - Нүдний эвэрлэг шархална, нүдэнд цагаа бууж, үхжилт явагдана. <p>Арьс:</p> <ul style="list-style-type: none"> - Цавь, бэлэг эрхтэн орчим, суга, хүзүү гэх мэт биеийн халуун, чийглэг хэсгүүд өртөлтөд илүү эмзэг байдаг. - 6-12 цагийн дотор арьс улайна. - 13-24 цагийн дотор тунгалаг шар өнгөтэй, шингэн агуулсан цэврүү үүснэ (хамгийн удаандаа 48-72 цагт). Шингэн нь мастард агуулаагүй, амархан хагардаг, 1,4 долоо хоногийн турш аажуу эдгэрнэ. - 42-72 цагийн дотор загатнаа үүснэ. - Хаван бууж, несөөжнө. - Нянгийн хоёрдогч халдвар үүсэх эрсдэлтэй. <p>Амьсгалын эрхтний тогтолцоо:</p> <ul style="list-style-type: none"> - Хоолой сөөж, 2-6 цагийн дотор дуу гарахаа болино. - Бусад шинж тэмдэг удаан, 1-3 хоногт илэрнэ. - Эхлээд хий, аажимдаа цэртэй ханиалгана, цэрээр үхэжсэн салст гадагшилна. - Амьсгаадна - Халуурна - Хоолой, гүйлсэн булчирхай, тагнай, хүүхэн хэл, залгиур хоолой болон цагаан мөгөөрсөн хоолой улайж хөөж хавагнах, юм залгихад
----	---	---	---

		<p>хөндүүрлэнэ. Хавагнана, 1-3 өдөрт шархална. Хуурамч мембран болон хаван нь залгиур хоолой бөглөрлийн шалтгаан болно.</p> <ul style="list-style-type: none"> - Химийн бодисын шалтгаант уушгины үрэвсэл, амьсгалын цочмог хямралын хам шинж илэрнэ. - Бактерийн хоёрдогч халдвар үүсэх эрсдэлтэй. - Үхэлд хүргэж болно. <p>Архаг өртөлт нь амьсгалын замын хавдрын эрсдэлийг нэмэгдүүлдгийг анхаарах нь зүйтэй.</p> <p>Люизит, хүнцэл агуулсан органик нэгдлүүдийн хордлогыг оношлох Нүд өртсөн тохиолдолд:</p> <p>Хөнгөн өртөлтийн үед даруй илрэх шинж:</p> <ul style="list-style-type: none"> - Зовхины булчин агших, хөндүүрлэнэ - Нулимс гоожин - Нүд хавагнана. - 1-2 долоо хоногийн дараа илаарьшиж, хэвийн байдалд орно. <p>Дунд болон хүнд зэргийн өртөлтийн үед илрэх шинж тэмдэг:</p> <ul style="list-style-type: none"> - Ихэвчлэн түр зуурын хараа алдалт үүснэ. - Эвэрлэгийн шархлаа, үүлшилт, үхжил үүснэ. - Нүдний алимын нэвчилт ихэснээс үүдэх урхагууд илэрнэ. <p>Арьсаар өртсөн тохиолдолд:</p> <ul style="list-style-type: none"> - Өртсөн даруй арьс халуун оргиж, түлэгдэлт мэдрэгдэнэ. - 15-30 минутын дотор улайлт үүснэ. - Улайсан газар 3-6 цагийн дотор цэврүү үүсч, улмаар өргөжин тэлсээр бүх биеийг хамарна (4 өдрийн дотор). Цэврүүний шингэн нь люизит агуулаагүй байх ба 1-4 долоо хоногийн дараа эдгэрнэ. - Арьсанд нөсөөжилт өөрчлөлт үүсэхгүй. - Шингэн хэлбэрээр өртсөн тохиолдолд арьсны гүн давхрагад хүнд түлэгдэл явагдаж, үхжилт үүсэж болно.
--	--	--

			<p>- Хоёрдогчоор нянгийн халдвар үүсэх боломжтой.</p> <p>Амьсгалын замаар өртсөн тохиолдолд:</p> <ul style="list-style-type: none"> - Нус гоожно, хоолой халуу оргиж, хөндүүрлэнэ. - Хоолой сөөнгөтөх, дуугарч чадахгүй болох, ханиалгана. - Ханиалгахад цэр гарна, ханиалгаар үхэжсэн салст гадагшилна. - Амьсгаадна - Халуурна - Хоолой, гүйлсэн булчирхай, тагнай, хүүхэн хэл, залгиур хоолой, төвөнх улайж, хөндүүр, хавагнан мөн шархлаа үүссэн байна. Хуурамч мембран үүсэх болон хоолой хавагнаснаас амьсгалын замын бөглөрөл үүсэж болно. - Бактерийн хоёрдогч халдвар үүсэх эрсдэлтэй. - Үхэлд хүргэж болно.
5.	Амьсгал боогдуулагч хортой бодисын хордлого	<p>-Фосген (COCl_2),</p> <p>-Дифосген ($\text{C}_2\text{Cl}_4\text{O}_2$),</p> <p>-Хлорпирин(гурван хлорт нитрометан (CCl_3NO_2))</p>	<p>Фосгены өртөлтийн үед илрэх шинж:</p> <p>Шууд:</p> <ul style="list-style-type: none"> - Нулимс гоожин, нүд өвдөнө - Зовхи татна - Дотор муухайрч, бөөлжинө - Дотор давчдан, цээжээр өвдөнө - Амьсгаадаж, амьсгаа давхцана - Артерийн даралт багасна - Зүрхний хэм удаашрах/хурдасна - Шингэнтэй харьцсан үед түлэгдэх, нүд гэмтэнэ - Хоолой зангирна - Цусны задрал явагдаж, богино хугацаанд нас барна <p>Далд үе:</p> <p>2-72 цагийн хооронд үргэлжилнэ</p> <ul style="list-style-type: none"> - Шинж тэмдэг илрэхгүй - Өртөгсөд эрүүл мэт харагдана - Өртөлтөөс хойш 72 цагийн дотор дасгал хийлгэж, шинж тэмдгийг илрүүлж болно. <p>Хожуу үе:</p> <p>Далд үеийн дараа</p> <ul style="list-style-type: none"> - Хөөсөрхөг шүлс ялгарах, амьсгаадах, ханиалгах, амьсгалахад хүндрэлтэй болно. - Зүрхний бус уушгины хаван үүснэ

